



Хэвлэлийн мэдээ  
2017 оны 9-р сарын 27

Холбоо барих  
97109009

**АмЧам Монгол “Оюуны өмчийн эрхээ хамгаалах анхан шатны мэдлэг” сэдэвт  
сургалтыг хамтран зохион байгууллаа**

УЛААНБААТАР, Монгол улс - 2017 оны 9-р сарын 27-нд Монгол дахь Америкийн Худалдааны Танхим, АНУ-ын Элчин Сайдын Яам болон Монгол Улсын Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (ОӨУБЕГ) хамтран “Оюуны өмчийн эрхээ хамгаалах анхан шатны мэдлэг” сэдэвт хагас өдрийн сургалтыг Бест Вестэрн Премьер зочид буудлын Сүлд танхимд зохион байгууллаа.

Сургалтанд Монголын тэргүүлэх бизнесүүдийн төлөөллөөс бүрдсэн АмЧам Монголын гишүүн байгууллагууд, Монгол Улсын оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын холбогдох албан тушаалтан, холбогдох төрийн байгууллагуудын болон АНУ-ын Элчин Сайдын Яамны төлөөлөл оролцлоо. Сургалтын үеэр АмЧам Монголын гишүүд болох Андерсон & Андерсон ХХН болон Хоган Ловеллс ХХН хуулийн фирмүүд оюуны өмчийн эрхийг хамгаалах чиглэлд чухал мэдээлэл бүхий илтгэл болон бодит кейс танилцууллаа. Мөн оюуны өмчийн эрхээ хамгаалахын тулд ОАУБЕГ, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Прокурорын ерөнхий газар, болон хувийн хуулийн фирмүүдтэй хэрхэн хамтран ажиллах боломжууд байдаг талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн юм.

АНУ-ын ЭСЯ-ны Худалдааны ахлах мэргэжилтэн Майкл Ричмонд нээлтийн үгэндээ оюуны өмчийн эрхээ хэрхэн хамгаалах тухай мэдлэгтэй байхын чухлыг онцлон хэлсэн үгэндээ “Монгол Улсад оюуны өмчийн эрхийг хамгаалах ямар арга хэрэгсэл, боломжууд байдаг гэдгийг мэддэг мөн тэдгээрийг ашиглаж чаддаг байх нь эрхээ хамгаалах хамгийн зөв арга” хэмээсэн юм.

АмЧам Монголын Бодлогын асуудал эрхэлсэн захирал О. Адъяа нээлтийн үеэр хэлсэн үгэндээ АмЧамын оюуны өмчийн эрхийг хамгаалах чиглэлд авч хэрэгжүүлдэг арга хэмжээ болон нөөц бололцооны тухайд хэлэхдээ “АмЧамын гишүүдээс бүрдсэн Оюуны өмчийн эрхийг хамгаалах хороо 2016 онд үүсгэн байгуулагдаад сэдвийн хүрээнд бодлогын голлох баримт бичгээ гаргаад тогтмол уулзалтаар энэ чиглэлд тулгарч буй бэрхшээлүүд болон гарцуудыг хэлэлцэн ажиллаж байгаа. Мөн АмЧам Монгол нь оюуны өмчийн эрхийг хамгаалах үндсэн 3 хуулийг шинэчлэх Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдэд орж холбогдох газруудад саналаа хүргүүлж ажиллаж байна” гэсэн юм.

**АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.